**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн 7-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХӨА-2024/150/НА-СТА-ТЗШ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Мөрөн сум<br>2024 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Б.Давааням<br>Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn<br><br>Аудитор: Г.Ичинхорлоо<br>Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 01/59

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН 7 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.УНДАРМАА ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн 7-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн 7-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант оны 12 дугаар сард улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,667,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, 150 хүүхдийн хүчин чадалтай хичээлийн байр ашиглалтад орсон боловч данс бүртгэлд тусгах шийдвэргүйн улмаас 2023 оны тайланд үндсэн хөрөнгөөр бүртгээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 147,440.6 мянган төгрөг буюу өмнөх оноос 8.5 дахин өссөн нь тайлант оны төгсгөлд дээд шатны төсөв захирагчаас цалин болон хоолны зардлууд дээр төсөвт шаардлагагүй санхүүжилт нэмж олгосон байгааг дараагийн аудитаар анхаарах асуудлаар тайланд тусгалаа.

**Бусад асуудлын хэсэг**

Тус газар нь тайлант онд “Хөтөлбөрийн хэрэгжилт, багшийн хөгжилд дэмжлэг үзүүлж, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарт ахиц гаргана” гэсэн зорилгын хүрээнд 9 зорилт дэвшүүлэн 95 хувийн биелэлттэй ажилласан байна.

6724040082

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **135,951,168.00** | **271,348,639.15** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 18,177,674.25 | 147,440,602.99 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 18,177,674.25 | 147,440,602.99 |
| **3121** | **Төгрөг** | 18,177,674.25 | 147,440,602.99 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 18,177,674.25 | 147,440,602.99 |
| **33** | **АВЛАГА** | 1,420,450.00 | 1,420,450.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,420,450.00 | 1,420,450.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,420,450.00 | 1,420,450.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 116,353,043.75 | 122,487,586.16 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,932,550.37 | 1,130,500.00 |
| 35130 | Эм боох материал | 2,932,550.37 | 1,130,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 113,420,493.38 | 121,357,086.16 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 130,000.00 | 00.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 63,100.00 | 00.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 4,850,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,850,614.42 | 8,456,585.63 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 108,376,778.96 | 108,050,500.53 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **693,940,262.01** | **434,891,002.43** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 693,940,262.01 | 434,891,002.43 |
| **392** | **Биет хөрөнгө** | 415,242,762.01 | 159,781,502.43 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 450,769,000.00 | 105,917,100.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -127,275,384.83 | -40,606,633.19 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 94,222,041.27 | 117,935,470.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -27,796,923.03 | -39,469,905.24 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,542,288.63 | 9,020,200.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -5,850,195.25 | -2,434,343.20 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 50,386,920.00 | 39,657,270.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -34,187,484.78 | -32,670,155.94 |
| 39217 | Ном | 2,432,500.00 | 2,432,500.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 278,697,500.00 | 275,109,500.00 |
| 39301 | Програм хангамж | 787,000.00 | 787,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -787,000.00 | 00.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 278,697,500.00 | 274,322,500.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **829,891,430.01** | **706,239,641.58** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **6,852,850.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 6,852,850.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 6,852,850.00 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 6,852,850.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **823,038,580.01** | **706,239,641.58** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 823,038,580.01 | 706,239,641.58 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 545,419,997.49 | 541,044,997.49 |
| 51101 | Өмч: - төрийн | 530,069,997.49 | 530,069,997.49 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | 15,350,000.00 | 10,975,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -153,726,965.05 | 165,547,817.61 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -153,726,965.05 | 277,971,756.04 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -112,423,938.43 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 431,345,547.57 | -353,173.52 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **829,891,430.01** | **706,239,641.58** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **819,885,924.00** | **1,111,787,680.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **43,445,024.00** | **45,028,580.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 43,445,024.00 | 45,028,580.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ | 27,650,800.00 | 35,313,080.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ | 15,794,224.00 | 9,715,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **776,440,900.00** | **1,066,759,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 632,644,800.00 | 946,285,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 632,644,800.00 | 946,285,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 143,796,100.00 | 120,473,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 143,796,100.00 | 120,473,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **828,085,615.81** | **975,353,900.92** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **828,085,615.81** | **975,353,900.92** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 828,084,722.75 | 952,340,157.29 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 506,011,515.85 | 621,526,746.44 |
| 210101 | Үндсэн цалин | 368,430,599.55 | 428,012,269.55 |
| 210102 | Нэмэгдэл | 106,372,796.96 | 169,175,482.98 |
| 210104 | Урамшуулал | 31,208,119.34 | 24,338,993.91 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 63,327,415.86 | 77,933,774.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,106,090.19 | 53,072,852.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,055,291.71 | 6,243,847.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,044,172.70 | 4,994,676.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,010,981.96 | 1,238,844.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,110,879.30 | 12,383,554.36 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 91,715,990.98 | 81,117,856.37 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,491,216.49 | 7,389,464.93 |
| 210302 | Түлш, халаалт | 76,717,201.88 | 65,769,858.94 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,507,572.61 | 7,958,532.50 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,288,850.00 | 5,461,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,810,000.00 | 1,935,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 275,000.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 661,750.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,542,100.00 | 3,526,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 75,176,271.38 | 80,115,129.16 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 176,233.33 | 1,942,250.37 |
| 210502 | Хоол, хүнс | 75,000,038.05 | 78,172,878.79 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,450,000.00 | 18,150,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,450,000.00 | 18,150,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 563,600.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 563,600.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 00.00 | 1,415,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,415,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 66,551,078.68 | 66,620,250.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,748,100.00 | 7,985,450.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,466,900.00 | 3,362,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 54,336,078.68 | 55,272,200.50 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 893.06 | 23,013,743.63 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 5,158,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 5,158,400.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 893.06 | 17,855,343.63 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 893.06 | 17,855,343.63 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-8,199,691.81** | **136,433,779.08** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 38,563.30 | 248,857,717.51 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 38,563.30 | 234,715,139.08 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 14,142,578.43 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -38,563.30 | -248,857,717.51 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-8,238,255.11** | **-112,423,938.43** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **776,440,900.00** | **1,066,759,100.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **776,440,900.00** | **1,066,759,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **632,644,800.00** | **946,285,900.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 632,644,800.00 | 946,285,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **143,796,100.00** | **120,473,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 143,796,100.00 | 120,473,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **758,263,225.75** | **937,496,171.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **758,263,225.75** | **937,496,171.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **758,262,332.69** | **914,482,427.63** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **506,011,515.85** | **621,526,746.44** |
| 210101 | Үндсэн цалин | 368,430,599.55 | 428,012,269.55 |
| 210102 | Нэмэгдэл | 106,372,796.96 | 169,175,482.98 |
| 210104 | Урамшуулал | 31,208,119.34 | 24,338,993.91 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **63,327,415.86** | **77,933,774.82** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 43,106,090.19 | 53,072,852.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,055,291.71 | 6,243,847.08 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,044,172.70 | 4,994,676.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,010,981.96 | 1,238,844.22 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,110,879.30 | 12,383,554.36 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **91,715,990.98** | **81,117,856.37** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,491,216.49 | 7,389,464.93 |
| 210302 | Түлш, халаалт | 76,717,201.88 | 65,769,858.94 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 10,507,572.61 | 7,958,532.50 |
| **2105** | **Нормативт зардал** | **72,933,710.00** | **83,583,750.00** |
| 210502 | Хоол, хүнс | 72,933,710.00 | 83,583,750.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **7,000,000.00** | **21,500,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 7,000,000.00 | 21,500,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,258,000.00** | **1,415,000.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,258,000.00 | 1,415,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **16,015,700.00** | **27,405,300.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,215,700.00 | 22,643,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,800,000.00 | 4,761,600.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **893.06** | **23,013,743.63** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **00.00** | **5,158,400.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 5,158,400.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **893.06** | **17,855,343.63** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 893.06 | 17,855,343.63 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **18,177,674.25** | **129,262,928.74** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **18,177,674.25** | **129,262,928.74** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **18,177,674.25** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **18,177,674.25** | **147,440,602.99** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Бусад** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 266,722,497.49 | 106,417,723.52 | -108,514,498.03 | 00.00 | 264,625,722.98 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **266,722,497.49** | **106,417,723.52** | **-108,514,498.03** | **00.00** | 264,625,722.98 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -13,053,238.65 | 00.00 | -13,053,238.65 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **545,419,997.49** | **431,345,547.57** | **-153,726,965.05** | **00.00** | 823,038,580.01 |
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **545,419,997.49** | **431,345,547.57** | **-153,726,965.05** | **00.00** | 823,038,580.01 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 431,698,721.09 | 00.00 | 431,698,721.09 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **545,419,997.49** | **431,345,547.57** | **277,971,756.04** | **00.00** | 1,254,737,301.10 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -431,698,721.09 | 00.00 | 00.00 | -431,698,721.09 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | -4,375,000.00 | 00.00 | 00.00 | 00.00 | -4,375,000.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -112,423,938.43 | 00.00 | -112,423,938.43 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **541,044,997.49** | **-353,173.52** | **165,547,817.61** | **00.00** | 706,239,641.58 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 18,177,674.25 | (18,177,674.25) | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,084,929,700.00 | 919,640,827.63 | 165,288,872.37 | 84.77 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,084,929,700.00 | 919,640,827.63 | 165,288,872.37 | 84.77 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 1,079,771,300.00 | 914,482,427.63 | 165,288,872.37 | 84.69 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 738,834,500.00 | 621,526,746.44 | 117,307,753.56 | 84.12 |
| 210101 | Үндсэн цалин | 471,541,000.00 | 428,012,269.55 | 43,528,730.45 | 90.77 |
| 210102 | Нэмэгдэл | 240,452,000.00 | 169,175,482.98 | 71,276,517.02 | 70.36 |
| 210104 | Урамшуулал | 26,841,500.00 | 24,338,993.91 | 2,502,506.09 | 90.68 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 88,860,800.00 | 77,933,774.82 | 10,927,025.18 | 87.70 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 60,425,400.00 | 53,072,852.38 | 7,352,547.62 | 87.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,108,900.00 | 6,243,847.08 | 865,052.92 | 87.83 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 5,686,800.00 | 4,994,676.78 | 692,123.22 | 87.83 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,422,100.00 | 1,238,844.22 | 183,255.78 | 87.11 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,217,600.00 | 12,383,554.36 | 1,834,045.64 | 87.10 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 98,973,200.00 | 81,117,856.37 | 17,855,343.63 | 81.96 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 8,400,200.00 | 7,389,464.93 | 1,010,735.07 | 87.97 |
| 210302 | Түлш, халаалт | 77,617,000.00 | 65,769,858.94 | 11,847,141.06 | 84.74 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,956,000.00 | 7,958,532.50 | 4,997,467.50 | 61.43 |
| 2105 | Нормативт зардал | 102,389,600.00 | 83,583,750.00 | 18,805,850.00 | 81.63 |
| 210502 | Хоол, хүнс | 102,389,600.00 | 83,583,750.00 | 18,805,850.00 | 81.63 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 21,500,000.00 | 21,500,000.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,500,000.00 | 21,500,000.00 | - | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 1,587,200.00 | 1,415,000.00 | 172,200.00 | 89.15 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 1,587,200.00 | 1,415,000.00 | 172,200.00 | 89.15 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,626,000.00 | 27,405,300.00 | 220,700.00 | 99.20 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,864,400.00 | 22,643,700.00 | 220,700.00 | 99.03 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,761,600.00 | 4,761,600.00 | - | 100.00 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,158,400.00 | 5,158,400.00 | - | 100.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 5,158,400.00 | 5,158,400.00 | - | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 5,158,400.00 | 5,158,400.00 | - | 100.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,066,759,100.00 | 1,048,903,756.37 | 17,855,343.63 | 98.33 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 946,285,900.00 | 946,285,900.00 | - | 100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 946,285,900.00 | 946,285,900.00 | - | 100.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 120,473,200.00 | 102,617,856.37 | 17,855,343.63 | 85.18 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 120,473,200.00 | 102,617,856.37 | 17,855,343.63 | 85.18 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 18,177,674.25 | (18,177,674.25) | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 147,440,602.99 | (147,440,602.99) | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 40.00 | 40.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 18.00 | 18.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 21.00 | 21.00 | - | 100.00 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | 451.00 | 451.00 | - | 100.00 |
| 630 | Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид | 451.00 | 451.00 | - | 100.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 451.00 | 451.00 | - | 100.00 |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО | - | - | - | - |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 33,947.8 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 33,947.8 мянган төгрөгийн алдааг залруулж, дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Тайлант оны 8 дугаар сард Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар ирсэн нэг бүр нь 3,978.2 мянган төгрөгийн 8 ширхэг зөөврийн компьютерыг бүртгэлд тусгаагүй орхигдуулсан байна. Элэгдлийн зардал 2,121.7 мянган төгрөг. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2-т бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэж заасныг зөрчсөн, Тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 0 мянган төгрөгийн 2 зөрчил[2] илэрснээс 0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг Хөвсгөл аймгийн 7-р цэцэрлэгийн дарга, нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт</u>:* Дотоод хяналтын ажлын хэсгийн төлөвлөсөн ажил, хийж хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалттай боловч илэрсэн зөрчил арилгуулах, цаашид сайжруулах талаар зөвлөмж хүргүүлж, зөрчил арилгах үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн эгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7.6-д “хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх” гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Дотоод хяналтын үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ илэрсэн зөрчлийг арилгуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагаа болон санхүү бүртгэлийн үйл ажиллагааг

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,
[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

сайжруулах талаар хэрэгжих боломжтой зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцож, тайлагнаж, үр дүнг хамт олны хурлаар хэлэлцүүлж ажиллах.

2.Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

*<u>Илрүүлэлт</u>:* Тус байгууллагад мөрдлөг болгон ажиллаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хэлбэрт шилжсэн болон боловсролын салбарын хууль эрх зүйн шинэчлэлд нийцүүлэн шинэчлэн боловсруулж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэж заасанд нийцээгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>*

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, стандартад орсон өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсруулах.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Дотоод хяналт хариуцлагатай холбоотой | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| НБББББ-тэй холбоотой | 1 | 0 | | | | | 1 | 0 |
| **Дүн** | **2** | **0** | | | | | **2** | **0** |